



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ
СПОРТЫН АРБИТР



ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ЗАРДЛЫН ЖУРАМ

2023 оны 10 дугаар сарын 20-ны
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 23/18 тоот
тогтоолын хавсралтаар батлав.

Нэг. Олон улсын маргааны ажиллагаанд

- 1.1 Допингийн давж заалдах комисст анхан болон давж заалдах журмаар ажиллагааг явуулахад энэхүү журам үйлчлэх бөгөөд зардлын хураамжийг доор дурьдсан дүнгээр тогтооно.

№	Өргөдлийн зардал	Комиссын зардал	/ам.доллар/
1	Комиссын зардал	1,500	

Хоёр. Дотоодын маргааны ажиллагаанд

- 2.1 Анхан болон давж заалдах журмаар өргөдөл, нэхэмжлэл гаргахад мөнгөн дүнгийн хэмжээгээр шаардлага гаргасан бол өргөдөл, нэхэмжлэлийн үнийн дүнгээс доорх хувь хэмжээгээр тогтооно. Үүнд:

№	Өргөдлийн үнийн дүн	Комиссын зардал	(Төгрөг)
1	10,000,000 хүртэлх	1,000,000 төгрөг	
2	10,000,001-50,000,000	1,000,000 дээр 10,000,000-аас дээш үнийн дүнгийн 8.5 хувиар	
3	50,000,001-100,000,000	1,500,000 дээр 50,000,000-аас дээш үнийн дүнгийн 7.5 хувиар	
4	100,000,001-200,000,000	2,000,000 дээр 100,000,000-аас дээш үнийн дүнгийн 4.5 хувиар	
5	200,000,001-500,000,000	2,500,000 дээр 200,000,000-аас дээш үнийн дүнгийн 2.5 хувиар	
6	500,000,001-1,000,000,000	7,425,000 дээр 500,000,000-аас дээш үнийн дүнгийн 2.0 хувиар	
7	1,000,000,001-аас дээш	12,425,000 дээр 1,000,000,000-аас дээш үнийн дүнгийн 1.0 хувиар	

- 2.2 Анхан болон давж заалдах журмаар өргөдөл, нэхэмжлэлийн шаардлагыг мөнгөн дүнгээр илэрхийлэх боломжгүй тохиолдолд зардлын хураамжийг доорх хэмжээгээр тогтооно. Үүнд:

№	Нэхэмжлэлийн үнийн дүн	Комиссын зардал
1	Комиссын зардал	5,000,000 төгрөг

- 2.3 Архивын болон нотлох баримтын хуулбар, лавлагаа гаргуулах тохиолдолд доорх хураамжийн хэмжээгээр тогтооно.

№	Утга	Төлбөр
1	Архивын хуулбар	Хуудас тутамд 5,000 төгтөг
2	Лавлагаа	50,000 төгтөг
3	Комиссоор дамжуулан авах лавлагаа, тодорхойлолт	200,000-5,000,000 төгрөг

Гурав. Комиссын ажиллагааны үндсэн зардал

- 3.1.1. Комиссын зардалд Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдон гарах дараах санхүүжилт хамаарна. Үүнд:
- 3.1.1.1. Комиссын үйлчилгээний
 - 3.1.2. Комиссын захиргааны үйл ажиллагааны
 - 3.1.3. Бүрэлдэхүүн болон нарийн бичгийн даргын ажлын урамшуулал, цалин хөлс
- 3.2. Өргөдөл, нэхэмжлэл гаргасан тал Комиссын зардлыг дээрх хувь хэмжээгээр төлнө.
- 3.3. Сөрөг өргөдөл, нэхэмжлэл гаргасан тал өргөдөл гаргагч, нэхэмжлэгчийн нэгэн адил Комиссын зардал төлнө.
- 3.4. Өргөдөл, нэхэмжлэгч гаргагч нь Комиссын зардлыг хэсэгчлэн төлөх талаар Комиссын даргад хүсэлт гаргаж болно. Хэсэгчлэн төлөх эхний зардлын доод хэмжээ Комиссын нийт зардлын 50 хувиас доошгүй байна. Үлдэх хэсгийг Комиссын хэрэг хянан шийдвэрлэх хуралдаанаас өмнө бүрэн төлсөн байна.
- 3.5. Комиссын зардал нь Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын холбооны дансанд Комиссын зардлыг төлбөр орсноор уг зардлыг төлсөнд тооцно. Уг зардлыг дансанд оруулах үүргийг

- өргөдөл гаргагч, нэхэмжлэгч, түүний гүйцэтгэлийг шалгаж хэрэгжүүлэх үүргийг Ажлын алба хариуцна.
- 3.6. Олон улсын маргааны Комиссын зардлын төлбөрийг АНУ-ын доллараар тооцож, 'Төв банкны тухай' хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу нэхэмжлэл гаргах өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож Монгол төгрөгөөр төлнө.
 - 3.7. Олон улсын маргаанд Комиссын зардал нь АНУ-аас өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд Комиссын зардлыг Комисст нэхэмжлэл гаргах үеийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцно.
 - 3.8. Дотоодын маргааны нэхэмжлэлийн үнийн дүн АНУ-ын доллараар эсвэл өөр улсын валютаар үнэлэгдсэн тохиолдолд Комисст өргөдөл, нэхэмжлэл гаргах өдрийн Монголбанкнаас зарласан албан ёсны ханшаар тооцож Комиссын зардлыг төлнө.
 - 3.9. Өргөдөл, нэхэмжлэл, сөрөг өргөдөл, нэхэмжлэлийн талаар Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийх явцад болон шийдвэр гаргах үедээ зарцуулсан бодит зардлыг тооцож тухайн Комиссын Бүрэлдэхүүн нэхэмжлэлийн үнийн дүнг тодорхойлж, зардлын хэмжээг тогтооно.
 - 3.10. Комиссын зардлыг буцаан олгохгүй.

Дөрөв. Комиссын ажиллагааны нэмэлт зардал

- 4.1. Нэмэлт зардалд тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд холбогдох бусад зардал багтана. Үүнд: зөвлөх, шинжээчтэй холбогдон гарах зардал, Комиссын шийдвэрээр гүйцэтгэсэн ажил нь үүрэгт хамаарахгүй бол ажлын хөлс, үзлэг хийхэд гарсан зардал, хэлмэрчлэл, орчуулга хийх, гэрчийн зардал, Бүрэлдэхүүний болон нарийн бичгийн даргын томилолтын зардал, Комиссын байнгын байрлах газраас өөр газарт Комиссын хэрэг хянан шийдвэрлэх хуралдаан хийсэнтэй холбогдсон зардал болон бусад зардал орно.
- 4.2. Комисс аль нэг талаас эсвэл талуудаас хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой нэмэлт зардлыг урьдчилан төлүүлнэ. Нэмэлт зардалд төлсөн төлбөр илүү гарсан тохиолдолд Комиссын шийдвэр гарсны дараа тухайн илүү төлбөрийг буцаан олгоно.

Тав. Комиссын ажиллагааны зардлаас буцаан олгох

- 5.1. Бүрэлдэхүүн Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг буруутай талаас нөхөн төлүүлэх шийдвэр гаргаж болно.

Зургаа. Комиссын ажиллагааны зардлын талаарх талуудын эрх

- 6.1. Аль нэг тал Комиссын ажиллагаатай холбогдон өөрөөс гарсан нэмэлт зардлыг буруутай талаас нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхтэй бөгөөд нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр энэхүү журамд заасны дагуу Комиссын зардлыг төлнө.
- 6.2. Аль нэг талын хүсэлтээр Комиссын хуралдаанд орчуулга хийх, баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг хүсэлт гаргасан тал төлнө. Бүрэлдэхүүний санаачлагаар баримт бичгийг орчуулах бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө. Хэрэв талууд харилцан тохиролцон хуралдааныг Монгол хэлээс өөр хэлээр явуулахаар бол орчуулгын зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.
- 6.3. Аль нэг талын хүсэлтээр шинжээч томилох бол шинжээчийн зардлыг хүсэлт гаргасан тал, Бүрэлдэхүүний санаачлагаар шинжээч томилох бол шинжээчийн зардлыг талууд тэнцүү хувааж төлнө.